

БАТЛАВ.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД

Т.БАДАМЖУНАЙ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАТБОЛДЫН  
ХХААХҮЯ-НД АЖИЛЛАХ ҮЕД ӨГСӨН ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2009 оны 12 дугаар сар 14

№	Ерөнхий сайдын өгсөн үүрэг	Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	Хариуцах газар	Хугацаа
1	2	3	4	5
1	Өндөр ашиг шимтэй мах, сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй, өндөр технологитой үйлдвэр бүхий хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн цогцолборууд бий болгож, хот суурингийн хүн амыг үйлдвэрийн аргаар боловсруулсан баталгаат мах, сүүгээр хангах зорилтыг үндэсний үйлдвэрлэлээр бүрэн шийдвэрлэх	Зарим томоохон хот суурин газрын орчимд сууний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй бий болгоход зээлийн дэмжлэг үзүүлэх	МААБХЗГ	II улиралд
		Махны чиглэлийн үхэр, хонины цогцолбор аж ахуйг аймгийн төв, хот суурингийн ойролцоо байгуулах аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих	МААБХЗГ	II улиралд
		Мал аж ахуйн өндөр технологитой үйлдвэр, хүнс, хөдөө аж ахуйн цогцолбор бий болгоход зээлийн дэмжлэг үзүүлэх	ЖДҮГ	Жилдээ
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан \2.3.12-д\ зорилтын дагуу мал сүргийг эрүүлжүүлэх ажлыг тодорхой бодлого, төлөвлөгөөтэй, олон улсын жишиг, стандартын дагуу хэрэгжүүлэх, улмаар экспортод гаргах мах, махан бүтээгдэхүүний хэмжээг эрс нэмэгдүүлэх	Мал эмнэлгийн сайн засаглал ажил үйлчилгээг сайжруулах 2010-2021 оны стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээ авах	ХХААХҮЯ МЭҮГ	Жилдээ
		Баруун бүсийн 5 аймгийг шүлхий өвчний вакцин хэрэглээгүй “эрүүл бүс” болгох асуудлыг олон улсын байгууллагаар баталгаажуулах	ХХААХҮЯ МЭҮГ	IV улирал
		Малын гоц халдварт шүлхий, шувууны томуу, гахайн мялзан, хонь ямааны цэцэг өвчнөөр тайван статусыг хадгалан сэрэмжлэн дархлаажуулах ажлыг зохион байгуулан хэрэгжүүлэх	МЭҮГ	III-IV улиралд
		Адууны ям, үхэр, тэмээний бруцеллёзын тархвар, халдварын байдлыг хот айл,	МЭҮГ Аймаг, нийслэли	II-IV улиралд

		баг, сумын түвшинд тандалтаар тогтоож, эрүүлжүүлэх арга хэмжээний стратеги төлөвлөлт, бодлогыг боловсруулах	йн ХХААХҮГ, Мал эмнэлгийн алба	
3	Газар тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн зорилтыг бүрэн хэрэгжүүлж, үр тариа, төмс, хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах, хураан авч буй ургацын чанар, стандартын шаардлага хангахуйц түвшнийг дээшлүүлэх	“Атрын 3 дугаар аян” тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан 296.0 мянган га-д үр тариа, төмс 13.2 мянган га-д, хүнсний ногоо 7.1 мянган га-д, малын тэжээл 6.1 мянган га-д тарьж үр тариа 407.0 мянган тн, төмс 158.5 мянган тн, хүнсний ногоо 93.3 мянган тн, нийт 658.8 мянган тн авч 270.0 мянган га-д уринш боловсруулна.	ГТБХЗГ	Жилдээ
		Усалгаатай тариалах талбайг 2400 га-гаар нэмэгдүүлнэ.		Жилдээ
		Үр тариа хадгалахад зориулан 10-12.0 мянган тн-ы багтаамжтай элеваторыг ашиглалтад оруулна.		Жилдээ
		Хүлэмжийн тариалалтыг 2009 оныхоос 10 хувиар нэмэгдүүлнэ.		Жилдээ
		Хөрс боловсруулах болон ургац хураалтын техникийг 2009 онд хүрсэн түвшингээс 10 хувиар нэмэгдүүлнэ.		Жилдээ
4	Мал аж ахуй, газар тариалангийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх тогтцолцоог чанаржуулах, салбартаа ажиллаж байгаа тариаланч, механикжуулагч, инженер, зоотехникч, малын эмч, агрономч зэрэг мэргэжлийн хүмүүсийн мэдлэг, ур чадварыг орчин үеийн шинэ технологи, менежментийн арга ухаанд давтан сургах чиглэлээр тодорхой ахиц гаргах зэрэг асуудлаар тодорхой бодлого, төлөвлөгөө боловсруулах	Аймаг, сумдад шаардлагатай байгаа мал аж ахуйн болон газар тариалангийн чиглэлийн боловсон хүчний талаар судалгааг орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран гаргах	ТЗУГ	I улиралд
		Судалгааны дүнд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах		III улиралд
		Салбарын мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, туршлага судлах зорилгоор гадаад улс орнуудад болон дотоодын нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулагдах сургалт, семинарт хамруулах хүмүүсийн тоог нэмэгдүүлэх		Жилдээ

5	Халх голын бүс нутагт тариалан эрхлэлтийг дахин сэргээх ажлын талаар тодорхой бодлого, төлөвлөгөөг боловсруулж танилцуулах	Дорнод аймгийн Халхголын бүс нутагт газар тариалангийн зориулалтаар иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж буй атаршсан 30000 га тайлбайг хууль тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу ашиглуулах асуудлыг судлаж Засгийн газарт танилцуулах	ГТБХЗГ	II улиралд
		Бүтээгдэхүүн хуваах гэрээт тайлбайн газар тариаланд ашиглаж болохоор судлагдсан газрыг хөдөө аж ахуйн эдэлбэр газар болгох асуудлыг судлаж Засгийн газарт танилцуулах	ГТБХЗГ	III улиралд

-----oOo-----